




СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.11.12 №44 (10721)

Үнэ 500 төгрөг

— Дугаар эрхэлсэн дэд ахлагч Т.ИДЭР

Б.Азжаргал: ЭР ХҮЧНИЙ ХААХ ЁСТОЙ АЛБА ТЭЖ "ПЛАШУУРДСАН"



Дэлхийн нийтийг хамарсан "Covid-19" цар тахлын улмаас 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг Улаанбаатар хотод зохион байгуулаагүй. Ингэснээр хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар цэргийн албанд явах хүсэлтэй залуусын тоо нэмэгдсэн талаар албаныхан мэдэгдсэн. Энэ удаа хугацаат албанд ирсэн дайчдын цэргийн анхан шатны сургалтад хамрагдаж буй өдрүүд үргэлжилж байна.

Сониныхоо энэ удаагийн дугаараар 2020 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар Нийслэлийн Баянзүрх дүүргээс татагдан Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид алба хаахаар ирсэн байлдагч Б.Азжаргалыг танилцуулж байна. Тэр бээр Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн хоёрдугаар дамжаанд суралцаж байхад нь цэргийн зарлан дуудах иржээ.

(Үргэлжлэл нь VIII нүүрт)

Хошууч генерал Ж.Бадамбазар: ЗОХИОН БАЙГУУЛЖ, ӨРСӨЛДӨЖ, АЖИГЛАГЧААР ОРОЛЦОХОД БЭЛЭН



"Олон улсын цэргийн наадам"-д оролцогч болон зохион байгуулагч, ажиглагч орнуудын Зэвсэгт хүчний удирдлагуудын цахим хурал боллоо. Тус хуралд Монгол Улс, ОХУ, БНХАУ, Азербайжан, Армен, Беларусь, Казахстан, Киргиз, Узбекистан, Шри-Ланк зэрэг 13 орны төлөөлөгчид оролцсон бөгөөд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг төлөөлж ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, Сургалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга, Биений тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ болон бусад албаны хүмүүс оролцсон юм.

Энэхүү наадмыг ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас жил бүр уламжлал болгон 10 гаруй оронд 30 гаруй төрлөөр зохион байгуулсаар ирсэн. Монгол Улсын хувьд 2019 онд оролцогч орноос зохион байгуулагч орны эгнээнд шилжиж, "Аравт" морин цэргийн анхдугаар олон улсын уралдааныг амжилттай эх нутагтаа зохион байгуулж, "Танкийн биатлон", "Мэргэн буудагчийн зааг", "Инженерийн томьёолол", "Хээрийн гал тогоо", "Зэвсгийн мастер",

"Цэлмэг тэнгэр", "Артиллерийн галын мастер", "Хурдач радист" зэрэг тэмцээнд оролцогч болон ажиглагчийн статустайгаар оролцож ирсэн. Харин 2020 онд зохион байгуулагдсан "Олон улсын цэргийн наадам"-д Монгол Улсын Онцгой комиссын шийдвэрээр оролцоогүй юм.

Энэ удаагийн цахим хурлын эхэнд ОХУ-ын талаас "Олон улсын цэргийн наадам-2020"-ын уралдааны бэлтгэл, явц, дүн, оролцогч орнуудын үзүүлсэн амжилт зэргийг тодотгов. Ялангуяа, дэлхий нийтээр цар тахлын нөхцөл байдал хүндэрсэн ч баг, тамирчдаа илгээж оролцуулсан зарим орны удирдлага, Зэвсэгт хүчинд талархал илэрхийлж байлаа. Үүний дараа "Олон улсын цэргийн наадам-2021"-ийг хэрхэн зохион байгуулах талаар танилцуулж, дэлхий нийтээр тархсан цар тахлын нөхцөл байдлаас хамааран зохион байгуулалтын зарим асуудлуудыг дахин хэлэлцэх шаардлагатай ямар уралдаан тэмцээнийг аль оронд зохион байгуулах саналтай буйгаа дуулгалаа. "Монгол Улсын хувьд "Аравт" олон улсын морин цэргийн уралдаан болон "Цэргийн

авто ралли"-г зохион байгуулах боломжтой. Та бүхэнд дадлага туршлага их бий" гэж ОХУ-ын талаас нэмж тодотгосон. Мөн энэ үеэр ирэх жилийн цэргийн наадамд улс орнуудын үндэсний соёлыг сурталчлах "Хил хязгааргүй нөхөрлөл" фестивалийг наадмын 31 дэх төрөлд тооцооор боллоо. Өөрөөр хэлбэл, оролцогч орнууд өөрсдийн орны соёл, урлаг, ёс заншлыг сурталчилсан дуу, бүжиг, бусад урлагийн төрлөөр уралдаанд оролцох боломжтой юм.

Хурлын төгсгөлд Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар "Манай улсын хувьд урьдын адил зарим тэмцээнээ бие даан зохион байгуулж, бусад тэмцээнд өрсөлдөж ажиглагчаар оролцох болно. Бие бүрэлдэхүүний хувьд бэлэн гэдгээ илэрхийлье. Гэхдээ бидний эцсийн шийдвэр дэлхий нийтээр тархсан цар тахлын нөхцөл байдал болон Монгол Улсын Онцгой Комиссын шийдвэрээс хамаарна" гээд зарим уралдаануудын дүрэм болоод бусад асуудлаар харилцан ярилцсан юм.

МӨРДЭСТ ХОСУУД АМИНЫ ОРОН СУУЦТАЙ БОЛЛОО



Зэвсэгт хүчний 310 дугаар анги, Тээврийн цагдаагийн алба хамтран алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд хандивын үйл ажиллагаа өрнүүлэн залуу гэр бүлийг амины шинэ орон сууцтай болгожээ. Тодруулбал, Төмөр зам дахь Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Шишигжаргал түүний гэргий Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Ажиллагааны удирдлагын тасгийн нярав, дэд ахлагч Б.Янжмаа нар шинэхэн сууцнаа хүлээж авлаа.

Дээрх хоёр байгууллагын хамт олон "ТВ9" телевизийн "Мөрөөдөл биелдэг юм" нэвтрүүлэг, Б.Агваандаш

захиралтай "Ариун нар хаус" ХХК-тай хамтран ийнхүү тэдэнд уг сууцыг барьж өгчээ. Энэ талаар Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн захиргагч, хурандаа Ж.Баясгалан "Тээврийн цагдаагийн албанаас манай ангид алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд хамтран ажиллах санал тавьсан. Энэ саналыг бид баяртайгаар хүлээн авч нэг өдрийнхөө цалинг хандивлан барилгын ажилд нь хүн, хүчний дэмжлэгийг үзүүлсэн. Ингээд 21 хоногийн хугацаанд 35 сая төгрөгийн өртгөөр 52м² талбай бүхий амины орон сууцыг ашиглалтад оруулан залуу гэр бүлдээ хүлээлгэн өглөө" гэв.

Гэрийн эзэн, цагдаагийн ахлагч Б.Шишигжаргал "Миний

бие Төмөр замын Цагдаагийн газарт зургаа дахь жилдээ алба хааж байна. Ажлын шаардлагаар сард 14-15 хоног томилолтоор явдаг. Энэ хугацаанд эхнэр маань л ар гэрийн ажлаа хариуцан үлддэг. Өмнө нь гэр бүлээ даарж байгаа болов уу гэж санаа зовдог байсан. Харин өнөөдөр ийм сайхан тохилог амины сууцтай боллоо. Хамт олондоо маш их баярлалаа" гэсэн юм. Дэд ахлагч Б.Янжмаа "Бид хоёр тохилог өргөөтэй болох мөрөөдлийнхөө талаар дандаа ярьдаг байсан. Гэхдээ хоёр байгууллага нийлээд бидэнд ингэж тусламж үзүүлнэ гэж зүүдэлж ч явсангүй. Та бүхэнд маш их баярлаж байгаагаа чин сэтгэлээсээ илэрхийлье" гэв.

АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДЛАА

Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Батлан хамгаалах салбар 2020, 2021, 2022, 2023, 2024" цуврал номыг бүтээх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг зохион байгууллаа. Энэхүү ажлын хэсгийн үндсэн үүрэг, чиглэл нь дээрх номуудыг бүтээж Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнээс

хэрэгжүүлж буй бодлого, зорилт, үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах үндсэн зорилготой юм.

Ажлын хэсгийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг ахлах ба Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, сайдын зөвлөх, Батлан хамгаалах яам, Зэвсэгт

хүчний Жанжин штабын зарим газар, хэлтсийн дарга нар, харьяа байгууллагуудын удирдлагын бүрэлдэхүүн уг номыг бүтээх ажилд оролцохоор шийдвэрлэжээ.

Энэ удаагийн хуралдаанаар уг номын ерөнхий агуулга, бүтэц, албан тушаалтнуудын ажил, үүргийн хуваарийг тодотгон холбогдох үүрэг, чиглэлийг өглөө.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газраас 2021-2025 оны хичээлийн жилд зарласан Вест Пойнт хот дахь Хуурай замын цэргийн сургууль, Аннаполис хот дахь Тэнгисийн цэргийн сургууль, Агаарын цэргийн сургуульд тус тус суралцах сонгон шалгаруулалтад Монгол Улсаас нэр дэвшигч оролцуулах хуваарь ирсэн байна.

Сонгон шалгаруулалтад оролцож байгаа нэр дэвшигч нь 17-22 настай байх бөгөөд сурлагын дүнгээрээ дунд сургуульдаа шилдэг 10 сурагчдын тоонд багтдаг байх ёстой. Түүнчлэн алгебр, геометр, тригонометрын хичээлийг заавал заалгаж, үзэж судалсан байна.

Нэр дэвшигч нь АНУ-ын хоёр төрлийн ерөнхий боловсролын шалгалт болох "Сурах ур чадварын шалгалт (SAT), Америкийн коллежийн шалгалт (ACT)-ын аль нэгийг 2020 оны 12 дугаар сараас өмнө өгсөн байх шаардлагатай. Шалгалт өгсний дараах дүнгээ ACT, SAT-д бүртгүүлэх маягтад бөглөөд Хуурай замын цэргийн сургууль руу "SAT-2924", "ACT-2976", Тэнгисийн цэргийн сургууль руу "SAT-5809", "ACT-1742", Агаарын цэргийн сургууль руу "SAT-4830", "ACT-0530" кодын хамт илгээнэ. Англи хэлний түвшин тогтоох шалгалт (TOEFL)-д 98-аас дээш оноо авсан байх ёстой. Англи хэлний шалгалтын дүнгээ мөн суралцах сургуулиасаа шалтгаалан дээрх кодуудын хамт илгээнэ.

Мөн хичээлээс гадуурх нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, нэмэлт дугуйлан, дамжаануудад хичээллэсэн бол давуу тал болно. Бие бялдрын хувьд тэсвэр хатуужлын өндөр бэлтгэлтэй байх ёстой. АНУ-ын Элчин сайдын яамны Батлан

хамгаалахын атташегийн албанаас биеийн тамирын шалгалтыг авна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://westpoint.edu/admissions/prospective-cadets/cadet-fitness-assessment-instructions>) цахим хуудаснаас авах боломжтой. Нэр дэвшигч нь АНУ-ын Элчин сайдын Батлан хамгаалахын атташегийн албанаас эрүүл мэндийн хуудас авч, эмчийн үзлэгээр орох болно гэдгийг анхаараарай.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Нэр дэвшигч нь цахим шуудангаар өөрийн бүтэн нэр, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, төрсөн он, сар, өдөр, хичээлийн дүн, SAT/ACT, TOEFL-ын оноо бусад нэмэлт мэдээллийг usdaomongolia@state.gov цахим хуудас руу 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө илгээнэ үү. Хэрэв нэр дэвшигч нь Монгол Улсад байхгүй бол урьдчилан мэдэгдэх ёстой.

АНУ-ын Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташегийн албанаас хамгийн шилдэг 3-6 нэр дэвшигчийг шалгаруулсны дараа сонгосон сургууль руу нь анкет, хувийн хэргийн хамт илгээх болно. Нэр дэвшигчид нь жил бүр зөвхөн өөрийн улс дотроо бусад олон улсын залуустай нийт 15 сургуулийн хуваарь дээр өрсөлддөг. Тиймээс Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташегийн албанаас сургуульд тэнцүүлэх болон сургах баталгааг өгөхгүй гэдгийг анхаарна уу.

Сонгон шалгаруулалтын бүх мэдээлэл, үйл ажиллагаа нь англи хэлээр явагдах тул англи хэлний гүнзгий мэдлэг шаардлагатай. Танд асуулт байгаа бол USDAOMONGOLIA@state.gov хаяг руу илгээнэ үү.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НАЙРАМДЛЫН СОЛОНГО ТАТАВ

"Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүд"-ийн хүрээнд болон ОХУ-ын "Ард түмний эв найрамдлын өдөр"-ийг тохиолдуулан "Найрамдлын солонго" олон үндэстний соёлын гала концерт ҮБХИС-ийн Соёлын төвд боллоо. Тус тоглолтод сургуулийн өмнөх насны болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их, дээд сургуулийн оюутнуудаас бүрдсэн 12 баг өөрсдийн бэлтгэсэн олон үндэстний бүжгээр өрсөлдлөө.

Оюутнуудын багаас тэргүүн байрт Үндэстний батлан хамгаалахын их сургуулийн дэргэдэх Монголын Залуучуудын Холбооны "Тэргүүний залуу" алтан медальт "Эрдмийн цуурай" бүжгийн хамтлаг шалгарав.



Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй НАТО-ийн цэргийн хүчний тэргүүлсэн "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын 13 дугаар ээлжийн Цэргийн багийн бие бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэл Зэвсэгт хүчний Сургалтын

нэгдсэн төвийн материаллаг баазыг түшиглэн амжилттай явагдлаа.

Сургалт бэлтгэлийн хаалтын ёслолын ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчний Сургалтын багийн захирагч, дэд хурандаа Л.Манчевский үг хэлсэн бөгөөд тэр бээр монгол цэргүүд сургалт бэлтгэлд идэвхтэй хамрагдаж, хоёр орны цэргийн багууд өмнөө тавьсан зорилгодоо амжилттай хүрснийг онцлон тэмдэглэв. Мөн бусдыгаа хошуучлан идэвхтэй суралцсан цэргийн алба хаагчид болон сургалт бэлтгэлийг амжилттай удирдаж явуулсан сургагч багш нарт Герман улсын Зэвсэгт хүчний дурсгалын зоос, буудлагын зэргийн тэмдэг гардуулав.

Монгол Улсын Цэргийн багийн захирагч, дэд хурандаа Э.Амартүвшин сургалт бэлтгэлийг амжилттай удирдан явуулсан ХБНГУ-ын Сургалтын багийн бүрэлдэхүүнд талархаж байгаагаа онцлоод багийн нийт бүрэлдэхүүнд дурсгалын зүйлийг гардуулан өгч хүндэтгэл үзүүлээ.

ШИНЭ УРАН БҮТЭЭЛҮҮДЭЭ ХҮРГЭНЭ

Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн үндэсний контент бүтээх зорилгоор Батлан хамгаалах яам, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулаад байна.

Энэхүү санамж бичгийн хүрээнд Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дарга, Соёлын төв өргөөний Ерөнхий менежер, хурандаа Г.Золзаяа тэргүүтэй тус чуулгын удирдлагын бүрэлдэхүүн Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Бодлого төлөвлөлт, маркетингийн хэлтсийн дарга Г.Гэрэл нарын удирдлага, уран бүтээлийн хэлтсийнхэнтэй уулзаж, шинэ үеийн Батлан хамгаалах яам үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтан зохион байгуулах зарим арга хэмжээ, урлаг, соёлын болон цэрэг-эх орны сэдэвт уран бүтээлийн асуудлаар хамтран ажиллах талаар хэлэлцлээ.



Тэд Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлан таниулахаас гадна улс орныг батлан хамгаалах болон эх орны бүтээн байгуулалтад гавьяат үйлс бүтээсэн алдартнуудыг дэлгэцийн бүтээлд мөнхлөх, хүүхэд, залуусыг соён гэгээрүүлэх, тэдний боловсрол, танин мэдэхүйд зориулсан

контент, мэдээ, мэдээлэл, нөвтрүүлүүдийг хамтран бэлтгэж нийтийн хүртээл болгох зэрэг олон ажлыг төлөвлөсөн бөгөөд тус чуулгатай хамтран үзүүлэх хэд хэдэн тоглолт, уран бүтээлүүд нь үзэгчдийн таашаалд нийцэх биз ээ.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын хамт олон цэрэг-эх орны сэдэвт шинэхан уран бүтээлүүдээ толилуулахаар бэлтгэл ажилдаа ороод байна.

БИД ҮБХИС-ИЙН "БҮТЭЭГДЭХҮҮН"

Ирэх онд Монгол Улсад Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баяр тохиож байгаагийн зэрэгцээ манай улсын хэмжээнд олон байгууллага, хамт олны 100 жилийн ой давхар тохиох юм. Эдгээр байгууллагын нэг бол Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэгтэй байгууллагуудын удирдах болон гүйцэтгэх албан тушаалдаа ажиллаж буй олон мянган генерал, офицер, ахлагч, мэргэжилтэн, ахмад дайчдыг бэлтгэн гаргасан, залуу үеийг бэлтгэж буй Үндэсний батлан хамгаалахын их сургууль юм.

Тус сургуулийг төгссөн зарим бүрэлдэхүүн зохион байгуулалтад орж, ҮБХИС-ийн 100 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор уулзалт, яриа хийж байгаатай нь таарлаа. Ингээд БХИС-ийн Ерөнхий зориулалтын цэргийн сургуулийн Ерөнхий цэргийн ангийн 2001 оны төгсөгч, ЗХЖШ-



ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, хурандаа Р.ЭНХБОЛДТОЙ хэдэн хорим ярилцлаа.

Ирэх жил ҮБХИС-ийн 100 жилийн түүхт ой тохионо. Энэхүү ойг угтаж хамт сургууль төгссөн сонсогчид буюу "онжав"-ууд тань ямар нэгэн ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа болов уу?

-Тухайн үеийн БХИС-ийг 2001 онд төгсөгчдийн төлөөлөгчид 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр уулзалт хийж, ҮБХИС-ийн 100 жил, БХИС-ийг 2001 онд төгсөгчдийн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх комиссыг "онжав"-ууд дотроосоо томилж, зохион байгуулалттай,

төлөвлөгөөтэй ажлуудыг хэрэгжүүлэхээр санал нэгдээд байна.

Ямар ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа вэ?

-Бид хоорондоо ярилцаад ҮБХИС-ийн 100 жилийг тохиолдуулан төрөлх сургуульдаа ямар нэгэн бүтээлч ажлыг хийж үлдээх, өөрсдийнхөө 20 жилийн ойн баярт зориулаад зургийн цомог, дурсамжийн ном, клип, баримтат кино бүтээх мөн хүмүүнлэгийн ажлыг явуулахаар төлөвлөдөг байна.

Танай оны төгсөгчид бусад төгсөгчдөөс юугаараа онцлогтой бол ...

-1997 онд тухайн үеийн Цэргийн их сургуульд шалгалт

өгөөд тэнцсэн бидний нөхөд Монгол Улсын дөрвөн зүг, найман зовхисоос цугларч, цэргийн жагсаалд мөн дөрвөн жил хамт суралцаад, 2001 онд төгссөн. Ирэх жил бидний "онжав"-уудын төгсөлтийн 20 жилийн ой нь ҮБХИС-ийн 100 жилийн ойн баяртай давхцаж байгаагаараа онцлог болж байна. Мөн түүнчлэн Хилийн цэргийн "онжав"-ууд маань Хилийн цэргийн дээд сургууль шилжиж ирээд анхны элсэлт авахад нь тус сургуульд элсэн орсон ба ҮБХИС-ийн хашаанд яг бүтэн дөрвөн жил суралцаад төгссөн юм.

Хэдүүлээ төгссөн бол ...
-Тухайн үед Цэргийн их сургууль, дараа нь нэр

нь өөрчлөгдөөд Батлан хамгаалахын их сургууль болсон ба манай сургуулийн Ерөнхий зориулалтын цэргийн сургуулийг 80 гаруй, Хилийн цэргийн дээд сургуулийг 120 гаруй сонсогч төгсөж байжээ. Эдгээр төгсөгчид маань өнөөдөр ҮАБЗ, БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ЦЕГ, ОБЕГ, ТЕГ, Дотоодын цэрэг, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага мөн хувийн бизнесийн салбарт амжилттай ажиллаж байна.

Бусад төгсөгчдөд хандаж хэлэх зүйл бий юу?

-ҮБХИС нь түүхт 100 жилийн хугацаанд ойролцоогоор 80 орчим төгсөлтийг хийж, 200 гаруй мянган сонсогчид төгссөн Монгол Улсын дээд боловсролын ууган байгууллагын нэг юм. Мөн Батланхамгаалах, Зэвсэгтхүчин, Төрийн цэргийн байгууллагын удирдах бүрэлдэхүүнийг олон жил тасралтгүй бэлтгэж, Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулсан сургууль билээ. Иймд ирэх жил тохиох төрөлх ҮБХИС-ийнхаа 100 жилийн ойн баярт сургуулийн үе үеийн төгсөгчид санаачилга гарган ихээхэн идэвхтэй оролцохыг уриалах байна.

ХОЛБОО ҮГҮЙ БОЛ

Монгол Улсын Зэвсэгт хүчнийг олон төрөл мэргэжлийн цэргийн алба хаагчид бүрдүүлж, тэд эх орныхоо төлөө амь биеэ үл хайрлан алба, үүргээ гүйцэтгэдэг. "Соёмбо" сонин тэдгээр мянга мянган цэргийн алба хаагчдаа онцлох үүднээс Зэвсэгт хүчний анги, салбаруудад ажиллаж буй алба хаагчдын ажил үйлсийн талаар сурвалжлан уншигч олонд хүргэсээр ирсэн билээ. Энэ ч үүднээс Батлан хамгаалах салбарт цэргийн холбооны чиглэлээр 53 жилийн түүхийг өртөөлж буй Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн талаар онцоллоо.

Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны 1967 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн тушаалаар Холбооны тусгай батальоны орон тоонд өөрчлөлт оруулан тусгайлан баталж, маргааш нь буюу 1 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалаар тус яамны холбоог хариуцан, хангах үүднээс Холбооны тусгай ротыг байгуулсан нь өдгөөгийн Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн үндэс, суурь болжээ. Тус анги Зэвсэгт хүчний удирдлагын холбоог хангахдаа холбоо, мэдээллийн технологийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, ангийн штаб, төвүүдийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэн, бие бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг

барилгачдын баяраар баяр хүргэсэн хүн цөөнгүй байсан шүү хэмээн ангийн захирагч хошигноод амжив. Үнэхээр ангийнхаа төлөө гэсэн сэтгэл гаргаж, чадахгүй, мэдэхгүй гэж хойш суулгүй хүнд, хүчир ажлын ард гарч чадсанаар ангийн хамт олон маань хийсэн бүтээсэн ажлаасаа урам зориг авч, халуун, дулаан уур амьсгал ч бүрдсэн гэдгийг тэрээр мөн уламжилж байв.

Энэ ангийнхны бүтээлч ажлууд нэг, хоёроор тогтсонгүй. Энэ жил коронавирусын цар тахал дэлхий нийтэд аюулын харангыг дэгдээж улс орон даяар хөл хорио тогтоосон ч гэсэн Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийнхан энэ цаг хугацааг үр дүнтэй ашиглаж, ангийнхаа туслах аж ахуйг багагүй торджээ. Энэ талаар тус ангийн захирагчийн ар тал хариуцсан орлогч, хошууч Т.Энхтуулаас тодрууллаа.



Хошууч Т.Энхтуул

Тэрээр "Холбооны ангийн алба хаагчид гэдэг бусдаас онцлогтой. Учир нь, манай ангийн бүрэлдэхүүн ихэнхдээ холбооны зангилгаанд, хээрийн байрлалд эсвэл бусад анги, салбар, байгууллагад ажиллаж, холбооны техник хэрэгслийг засварлах, холбоог сэргээх зэрэг өөр өөр үүрэг гүйцэтгэдэг. Тийм ч учраас хоол, хүнс, материал хангалтыг хэрхэн зохион байгуулах вэ гэдгээс эхлээд багагүй зохицуулалт шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор алба хаагчдад ажиллах ая тухтай нөхцөл байдлыг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Ангийн байрлал төвийн шугам, сүлжээтэй холбогдоогүй учир уурын зуухны галлагаагаар дулааны асуудлаа шийддэг. Өмнө нь барилга, байгууламжууд хүйтний улиралд дулаанаа хурдан алддаг байснаас үүдэн алба хаагчид тав тухгүй орчинд ажилладаг байсан. Харин энэ жил бид гадна дулаалгын ажлыг өөрсдөө хийж дуусгасан. Үр дүнд нь, маш дулаахан ажлын орчныг бүрдүүлж чадсанаас сэтгэл хангалуун байгаа. Ирэх жилээс нэгдсэн төвийн шугам, сүлжээтэй холбоолах зорилт тавьж, ажил урагштай явж байна. Өнгөрсөн зун эмэгтэйчүүдийн зөвлөлөөс санаачлан ангийн хашаандаа 500 орчим суулгац цэцэг, 80 гаруй гоёлын мод тарьсан нь ангид ирсэн хэн бүхний нүдийг баясгаж, өнгө нэмсэн үйлдэл болсон. Мөн Төв аймгийн Алтанбулаг суманд байсан 270 орчим мал бүхий ангийн туслах аж ахуйг "Хонхорын дамжуулах төв"-ийн ойролцоо шилжүүлж авчирсан. Үүний сацуу тус газар хүнсний ногоо, чацарганыг тариалж байна. Бид бүхний гол зорилго бол туслах аж ахуйгаа хөгжүүлж, түүгээр дамжуулан алба хаагчдынхаа нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэх байсан. Энэ зорилгодоо ч хүрч чадсан. Цаашлаад долоогоно, монос зэрэг жимсний мод, ногооны зоорь, хүлэмж барих төлөвлөгөөтэй ажиллаж байна" гэв.

"Холбоогүй бол удирдлагагүй, удирдлагагүйгээр ялалтад хүрэхгүй" гэдэг холбоочдын уриа их зүйлийг өгүүлнэ. Дайны болон тайван цагийн алинд ч найдвартай холбоогоор хангахад холбооны инженер, техникийн ажилтнууд голлох үүрэгтэй. Тэр ч үүднээс орчин цагийн Зэвсэгт хүчинд холбоочдын үүрэг, оролцоо улам бүр нэмэгдсэн гэдгийг тус ангийн штабын дарга, дэд хурандаа П.Намжилдорж хэлж байв. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, цэргийн албаны талаар тус ангийн штабын даргаас тодрууллаа. Тэрээр "Бие бүрэлдэхүүний болон авто, холбооны техникийн бэлэн байдлыг нэлээд анхаарч ажиллаж байна. Мөн удирдлагаас өгсөн тушаал, шийдвэр болон цэргийн дүрэм, заавар, журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа байнга мөрдөж ажиллахыг хичээж байна. Ангийн үйл ажиллагааны цөм нь ангийн байрлалаас гадна "Орхон" холбооны суурин зангилгаа болон "Хонхорын дамжуулах төв"-д явагддаг. Холбооны анги гэдэг нь байнгын бэлэн байдлын түвшин илүү өндөр байхыг шаарддаг. "Штабын бэлтгэлээр тэргүүлэгч анги" шалгаруулах үзлэгт штабын хамт олон маань төлөвлөгөөний дагуу бэлтгэж шалгуулан нэлээн "дээгүүр давхилаа". Энэ арга хэмжээний хүрээнд удирдлагын хөдөлгөөнт байр болон байнгын байрлал дахь удирдлагын байруудыг шинээр төхөөрөмжилсөн" гэлээ.

Цэргийн холбоочид гэдэг цагийн байдлын ямар ч үед үүргээ мадаггүй биелүүлэх хариуцлагатай үүргийг хүлээсэн нарийн мэргэжилтнүүд. Тэдний энэ үүрэг нь

ЯЛАЛТ ҮГҮЙ

Зэвсэгт хүчний бүхий л үйл ажиллагаатай уялдаа холбоотой хэрэгждэг. Чухамхүү энэ чухал албыг гүйцэтгэхэд мэдээж байнгын сургалт, дадлага шаардлагатай. Энэ талаар тус ангийн Ажиллагааны удирдлагын тасгийн дарга, ажиллагааны ахлах офицер, хошууч Ө.Мөнх-Алдар



Хошууч Ө.Мөнх-Алдар

"Манай анги 2019-2020 оны сургуулийн жилд цэргийн сургалт, бэлтгэлээр бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадвар, албан тушаалын үүргээ алдаа мадаггүйгээр биелүүлэхэд сурган дадлагажуулах зорилгыг дэвшүүлэн ажилласан. Өнгөрсөн хугацаанд Холбоочдын тусгай тактикийн хээрийн сургууль, ЗХЖШ-ын даргын нэрэмжит цогцолбор шалгалтад амжилттай бэлтгэж оролцлоо. Энэ хүрээнд хээрийн нөхцөлд компьютер, сүлжээг хэрхэн ашиглаж болох вэ гэдэг дээр ач холбогдол өгч ажилласан. Холбоо бол цэргийн даргын чих, тагнуул бол нүд нь гэж хэлдэг. Цар тахалтай холбоотойгоор ЗХЖШ-аас дотооддоо болон гадаад улс орнууд руу видео хурлыг зохион байгуулах бүрд манай офицер, ахлагч нар техник хэрэгслийн бэлэн байдлыг хариуцан ажиллаж байна. Хэдийгээр тус анги энэ жил маш их ачаалалтай ажилласан ч Зэвсэгт хүчний хэмжээнд явагдсан бүхий л уралдаан, тэмцээнүүдэд идэвхтэй оролцсон. Сургалт бэлтгэлийн төлөвлөлтийг боловсруулж батлууллаа. Одоо хэрэгжүүлэх ажил эхэлж байна. Эхний ажил болгож офицеруудын заах арга зүйн цугларалтыг амжилттай зохион байгуулсан бол нийс сургуулийн жилийн нээлт, тактик, жагсаалын хичээлийг 11 дүгээр сарын 2-ны өдөр явуулсан. Бусад анги, нэгтгэлийн хувьд цаг үеийн ажлаас шалтгаалан 12 дугаар сараас хичээлийн шинэ жилийг эхлүүлэхээр болсон ч манай ангийн хувьд ЗХЖШ-аас зөвшөөрөл авч, хичээл сургуулиа эхлүүлээд явж байна. Бид энэ сургуулийн жилд үндсэн үүрэгт ажлынхаа зэрэгцээ түүхт ойнуудыг угтсан бүтээн байгуулалтын ажлуудыг хийж, ажиллах орчин нөхцөлөө улам сайжруулах, холбоо, мэдээллийн технологийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэн, сахилгын зөрчилгүй хамт олон болох зорилттой ажиллаж байна" гэв.

Үргэлжлүүлэн тус ангийн нэгэн чухал салбар болох Программ хангамжийн төвөөр зочиллоо. Тус төв нь Зэвсэгт хүчний хэмжээнд программ хангамж, мэдээллийн санг бий болгосны үндсэн дээр цэргийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд программ хангамжаар үйлчлэх зориулалттай чухал албаныхан. Өнгөрсөн жил "Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмийн SITMAF-2019" аппикэйшнийг зохион бүтээжээ. Түүгээрээ Батлан



Дэд хурандаа С.Даариймаа

хамгаалахын сайдын нэрэмжит 2019 оны шилдэг бүтээл шалгаруулах тэмцээнээс тусгай байрын шагналыг хүртсэн байна. Түүнчлэн энэ онд Зэвсэгт хүчний Жанжин штабын мэдээллийн сайтын баяжилтыг цаг тухайд нь хийж, салбарын захиалгат 10 гаруй программуудаас гадна төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой болон ҮАБЗ-өөс ирүүлсэн захиалгат программуудыг заагдсан хугацаанд нь чанартай боловсруулжээ. Хэдий тийм боловч боловсон хүчний нөөц дутмаг, шинэ залуу боловсон хүчнийг сургаж бэлтгэх шаардлага тулгарч байгаа гэдгийг тус

төвийн дарга, дэд хурандаа С.Даариймаа онцолж байв.

Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн алба хаагчид өнгөрсөн 6-8 дугаар сард "Орхон" зангилгаанаас "Хонхорын дамжуулах төв" хүртэл 24 километр газар сувагжилтыг хийж, шилэн кабелийг

шинээр татан хүн, хүч, цаг хугацаа шаардсан нүсэр ажлын ард гарчээ. Энэхүү ажилд оройлон оролцож, чухал үүргийг гүйцэтгэсэн алба хаагчдын нэг нь ангидаа 26 жил тасралтгүй алба хааж буй Кабель шугамын төвийн шилэн кабелийн технологийн мэргэжилтэн, сургагч ахлагч Г.Онолбаатар юм. Түүнийг Зэвсэгт хүчний холбоочид бүгд андахгүй мэднэ. Холбооны шугам, кабелийн асуудлаар ямар л хүндрэлтэй асуудал гарна, түүний нэр засварын багийн томилгоонд заавал багтдаг. Тэр ч бүү хэл, зарим анги, байгууллагуудаас албан бичигтээ түүний нэрийг бичиж анги, байгууллагадаа авчирч, гэмтэлтэй холбооны кабель шугамаа засуулдаг гэдгийг тус ангийнхан ярьж байв. Тэрээр зав чөлөө бага, ачаалалтай ажилладаг хэдий ч түүнтэй уулзах завшаан бидэнд олдлоо. Түүнээс ажил мэргэжлийнх нь тухайд тодруулахад "Цэргийн холбоо бол удирдлагаас өгсөн



Сургагч ахлагч Г.Онолбаатар

үүргийг анги, салбарт түргэн, шуурхай, найдвартай хүргэх гол хэрэгсэл. Миний үүрэг бол хариуцсан холбооны кабель шугамыг ямар нэгэн тасалдал, сааталгүй ажиллуулах явдал. Техник, технологи хөгжихийн хэрээр бидэнд тохиолддог байсан зарим бэрхшээлүүд багасах, нөгөө талаар шинэ бэрхшээл ч гарах болсон. Энэ зун манай ангийнхан Хонхорын чиглэлд шилэн кабель татах ажлыг хийж гүйцэтгэлээ. Ингэснээр зүүн чиглэлд байгаа нэгтгэл, ангиудын холбооны чанарт ахиц гарах боломж бүрдлээ. Ер нь аливаа ажилд үнэн сэтгэлээсээ, тууштай хандаж, улам туршлагажих гэдэг нь хамгийн чухал юм" гэв.

Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн өөр нэгэн үүрэг бол Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн шуудан илгээмжийг Улаанбаатар хот, түүний ойролцоо байгаа командлалууд, нэгтгэл, анги, цэргийн байгууллагууд болон Төрийн ордон, яамд, агентлагуудад хүргэх ажил юм. Энэ ажлыг Цэргийн шуудан илгээмжийн тасгийн хамт олон гүйцэтгэдэг бөгөөд



Ахлагч Ж.Энхтөр


тэдний ажил, үүргийн талаар тус тасгийн ахлах шууданч, ахлагч Ж.Энхтөрөөс тодрууллаа. "Манай тасаг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, түүний харьяа байгууллагуудыг өдөр тутмын шуудангийн үйлчилгээгээр хангах, дотооддоо хэвлэл түгээлтийн ажлыг хариуцдаг. Анги байгуулагдсан цагаас эхлэн үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн. Цэргийн шуудан илгээмжийг хот доторх болон алсын шуудан хэмээн хоёр ангилдаг. Алсын шуудан гэдэг нь Сонгино цэргийн хүрээ, Налайх цэргийн хүрээ, Их булаг цэргийн хүрээ гэх мэт нийслэл хотыг тойрон байрлаж буй анги, байгууллагуудыг хамардаг гэсэн үг. Дээрээс нь, орон нутгийн анги, салбарууд руу "Монгол шуудан" компаниар дамжуулан шуудан түгээдэг" гэв.

Ийнхүү тус ангийн шууданчтай ярилцсанаар Зэвсэгт хүчний 189 дүгээр ангиас бэлтгэсэн сурвалжилга өндөрлөсөн юм. Энэ ангийнхан холбооны тодотголтой инженер, техникийн ажилтан, алба хаагчид гэлтгүй шинийг сэдэж, шилдгийг бүтээж, ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтсийн удирдлагаас магтаалын үг сонсож, урамшиж яваа бүтээлч хамт олон төдийгүй бусад анги, салбар, байгууллагууддаа ч бас үлгэр дуурайл болон ажиллаж байна.

Дэд ахлагч Т.ИДЭР



ЦЭРГИЙН НИСЭХИЙНХЭН



Тухайн үеийн ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав 2010 оны 7 дугаар сард Афганистан улсад ажлын айлчлал хийх явцдаа Аюулгүй байдлыг дэмжих олон улсын хүчний болон Афганистан дахь Америкийн цэргийн хүчний командлагч, генерал Дэвид Петреаус болон Афганистан дахь НАТО-ийн сургалтын ажиллагааны командлагч, дэслэгч генерал В.Колдвелл нартай уулзахад тэдний зүгээс Афганистан улсын Агаарын цэргийн хүчний инженер, техникийн бүрэлдэхүүнийг "Ми-17" нисдэг тэргэн дээр сургах талаар манай талаас дэмжлэг хүссэн.

Дээрх ажлын айлчлалын явцад яригдсан "Ми-17" нисдэг тэргэний засвар, үйлчилгээний сургалтын бүлгийг ирүүлэх ажлын эрх зүйн болон бусад бэлтгэлийг хангах, хүлээн авч үүрэг гүйцэтгэх газар орны цагийн байдалтай танилцуулах, хамтран ажиллах хүмүүстэй уулзуулж цаашид ажиллах чиглэлийг тодорхойлох ажлыг тухайн үед Аюулгүй байдлыг дэмжих олон улсын хүчний төв штабт ажиллаж байсан Үндэсний ахлах төлөөлөгч, хурандаа П.Батжаргал гардан зохион байгуулсан юм.

АЖИЛЛАГААНЫ ӨМНӨХ БЭЛТГЭЛ

Тухайн үед Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч, бригадын генерал Т.Дашдэлэг "Нисдэг тэргэний техникийн засвар, үйлчилгээний сургалтын бүлэг"-ийн бие бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулан үүрэг, чиглэл өгсөн. Анхны бүлгийн бүрэлдэхүүнд англи хэлний орчуулагчаар ажиллагааны туршлагатай Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ахлах дэслэгч А.Мягмардорж, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн ахлах дэслэгч

П.Батбаяр, бүлгийн дарга, сургагч багш нараар Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн дэд хурандаа Ч.Болдбаатар, ахлах дэслэгч Ж.Цогтдорж, С.Энх-Амгалан, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн хошууч Д.Түвшинсайхан нар томилогдсон юм.

Ажиллагааны өмнөх бэлтгэлийг Тавантолгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд Афганистан Улсад үүрэг гүйцэтгэх хамгаалалтын ротын бие бүрэлдэхүүнтэй мөн БХИС-ийн ЦДС-ийн АДХЦ-ийн тэнхимд

7 хоног, Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн байрлалд 7 хоног тус тус зохион байгуулав. Энэхүү бэлтгэлийн явцад техникийн аюулгүйн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсний үндсэн дээр сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн болон тактикийн тусгай бэлтгэлийн хичээлийг түлхүү оруулж, болзошгүй цагийн байдлыг үүсгэн бүлгийн бүрэлдэхүүн хоёр хэсэгт хуваагдан үүрэг гүйцэтгэх хувилбараар тодорхой дадлагыг хийсэн нь үр дүнтэй болсон.

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



Зүүн гар талаас: Ахлах дэслэгч С.Энх-Амгалан, П.Батбаяр, хошууч Д.Түвшинсайхан, дэд хурандаа Ч.Болдбаатар, ахлах дэслэгч А.Мягмардорж, ахмад Ж.Цогтдорж

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ХОЁРДУГААР БҮЛЭГ



Дэд хурандаа Ж.Батсүх, ахмад У.Ундрах, ахлах дэслэгч Э.Хаш-Эрдэнэ, О.Аюурзана, Б.Бямбазаяа, Ч.Санждорж

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ГУРАВДУГААР БҮЛЭГ



Зүүн гар талаас: Дэд хурандаа Д.Батбаяр, хурандаа Ч.Түмэндэмбэрэл, Гантөмөр, дэд хурандаа С.Энхболд, С.Ганболд, ахмад Д.Шатаррагчаа, хошууч Б.Заяажаргал, ахмад Н.Батбаяр

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ЗОРИЛГО

Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах тухай, Зэвсэгт хүчний тухай, Улсын нисэхийн тухай Монгол Улсын хуулиуд, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цэргийн албыг зохион байгуулах заавар, Улсын нисэхийн инженерийн албаны заавар, НАТО-ийн Командлалын сургалтын хөтөлбөр, Монгол Улсын Цэргийн багийн хүч хэрэглэх дүрэм, Тогтсон ажиллагааны журам болон бусад удирдлагын баримт бичгийн хүрээнд Афганистан Улсын Агаарын цэргийн хүчний бие бүрэлдэхүүнийг "Ми-17" загварын нисдэг тэргэний хөдөлгүүрийн мэргэжлээр шилжүүлэн сургах дунд шатны сургалтыг зохион байгуулах.

ЗОРИЛТ

1."Ми-17" нисдэг тэргэний хөдөлгүүрийн мэргэжлээр шилжүүлэн сургах дунд шатны сургалтын хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, цаг, сэдвийн задлан, хичээлийн хуваарь, бусад шаардлагатай баримт бичгүүдийг стандартын дагуу боловсруулах сургалтыг зохион байгуулах;

2.АНУ-ын Агаарын цэргийн хүчний 440 дүгээр эскадрилийн Нисдэг тэргэний сургалтын хэсэг, Кабул дахь Афганистаны Агаарын цэргийн хүчний засвар, техникийн үйлчилгээний хорооны инженер, техникийн бие бүрэлдэхүүнд "Ми-17" загварын нисдэг тэргэний техник ашиглалт, нислэгийн бэлтгэлүүд болон техник үйлчилгээний ажлуудыг технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэх, нислэг, нислэгийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх;

3.Болзошгүй аюул, цагийн байдлын гэнэтийн өөрчлөлтийн үед тогтоосон хугацаанд, заагдсан районд тавигдсан үүргийг биелүүлэхэд бэлэн байх.

СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЕИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ

Нисдэг тэргэний техникийн засвар, үйлчилгээний сургалтын нэгдүгээр бүлгийн бүрэлдэхүүн нь өмнө тавьсан зорилго, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд сургалтыг зохион байгуулах газар орон, анги, танхим, ном, сурах бичгийн хүрэлцээ, өмнө нь сургалтыг зохион байгуулж байсан онцлог, туршлага зэргийг судалсан. Түүнчлэн ОХУ-д сургууль төгссөн офицеруудтай ажлын уулзалтыг зохион байгуулж, тухайн орны баяр, амралтын өдрүүдийн онцлог зэргийг харгалзан үзээд нисэх хорооны удирдлага, сургалтын офицеруудтай харилцан ярилцаад эхний ээлжинд "Нисдэг тэргэний техникийн засвар, үйлчилгээний сургалтын бүлэг"-ээс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хуваарийг хоёр янзын хувилбараар орос хэлээр боловсруулж, АНУ-ын Агаарын цэргийн хүчний нисэх хорооны удирдлага болон Афганистаны нисэх хорооны удирдлагын бүрэлдэхүүнд танилцуулж санал, бодлыг нь сонссон. Боловсруулсан баримт бичгээ англи болон паштун хэл рүү

хөрвүүлэн орчуулж, эхний ээлжийн сургалтыг зохион байгуулах тушаал, шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг боловсруулан 2010 оны 10 дугаар сарын 24-ний өдөр АНУ, Афганистаны нисэх хорооны удирдлагатай хамтран "Ми-17" загварын нисдэг тэргэний хөдөлгүүрийн мэргэжлээр суралцах цэргийн алба хаагчидтай уулзалт, ярилцлагыг хийж, хичээлийн нээлтийг зохион байгуулсан.

Афганистаны нисэхийн хорооны удирдлага болон зарим инженер, техникийн бүрэлдэхүүн, хуучнаар ЗХУ-ын Фрунзе, Краснодар хотын нисэхийн сургуулийг төгссөн төгсөгчид бидэнд дэмжлэг үзүүлж байсан ба АНУ-ын талаас ч нисэхийн сургалтын анхны бүлгийн бүрэлдэхүүнд өндөр ач холбогдол өгч сургалтын материаллаг бааз, сургалтад хэрэглэгдэх материал хэрэгслээр тусалж байсан. АНУ-ын нисэх дивизийн хэвлэлийн төлөөлөгч нь сургалтын нээлтийн ажиллагаанд оролцож бидний тухай хэвлэл мэдээлэлд бичин бидэнд их урам зоригийг өгсөн юм.

СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ОНЦЛОГ

Афганистан улсад явагдаж буй НАТО-ийн сургалтын ажиллагаа (НАТС-А)-ны ерөнхий хөтөлбөр, АНУ-ын Агаарын цэргийн хүчний 438 дугаар нисэх хорооны 440 дүгээр эскадрилийн ажиллагааны бодлого, төлөвлөлттэй уялдуулан Нисдэг тэргэний техникийн засвар, үйлчилгээний сургалтын бүлэг (НТТЗУСБ)-ийн гүйцэтгэх үүргийг "Ми-17 загварын нисдэг тэргэний хөдөлгүүр"-ийн мэргэжлээр шилжүүлэн сургах дунд шатны сургалтыг зохион байгуулах, АНУ-ын АЦХ-ний 440 дүгээр эскадрилийн нисдэг тэргэний сургалтын хэсэг, Кабул дахь Афганистаны АЦХ-ний засвар, техникийн үйлчилгээний хорооны инженер, техникийн бие бүрэлдэхүүнд "Ми-17" загварын нисдэг тэргэний техник ашиглалт, нислэгийн бэлтгэлүүд болон техник үйлчилгээний ажлуудыг технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэх, нислэгийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх зэрэг үндсэн үүргийг нэмж биелүүлэхээр заасан.

Сургалтын бүлгийн үйл ажиллагааг сараар төлөвлөж, хэрэгжилтийг нь зохион байгуулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хуваарь, сургалтад ашиглах бусад материалуудыг орос, англи болон паштун хэлээр боловсруулж Зэвсэгт хүчний Үндэсний ахлах төлөөлөгч, Цэргийн багийн удирдлага, АНУ-ын АЦХ-ний 438 дугаар хорооны 440 дүгээр эскадрилийн удирдлагаар хянуулан Афганистаны АЦХ-ний Кабул дахь Засвар, үйлчилгээний хорооны удирдлага, сургалтын албанд танилцуулсан ба ЗХЖШ-ын АДХЦ-ийн командлагчид сар тутмын илтгэх хуудас, өдөр тутмын болон долоо хоногийн мэдээ, сарын ажлын тайлан, тусгай мэдээ болон ЗХЖШ-ын АУГ-ын удирдамж, Үндэсний ахлах төлөөлөгчийн удирдамж, Цэргийн багийн удирдлагын өгсөн үүргийн дагуу зохион байгуулж явуулсан үйл ажиллагааны тайланг

нэгтгэн Цэргийн багийн ажиллагааны хяналтын төвд цаг тухайд нь илгээж байв.

Сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд сургагч багш нар хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хуваарийг сургалтын ажиллагаа явагдаж буй газрын нөхцөл байдалд ойртуулан, АНУ-ын АЦХ-ний 440 дүгээр эскадрилийн удирдлага, Афганистаны АЦХ-ний засвар, техникийн үйлчилгээний хорооны удирдлагаас тавьсан санал, хүсэлт, сургалтын бүлгийн сургалт явуулах боломжийг судлан, тооцоог нь гарган боловсруулсан. Афганистаны АЦХ-ний засвар, үйлчилгээний хорооны техникийн номын санд ашиглагдаж буй ном, сурах бичиг, техникийн хэвшүүлэх ажлын технологийн карт болон техник ашиглалтын гарын авлага, ном, сурах бичигтэй танилцан, судалгааг явуулсны үндсэн дээр сургалтад ашиглах конспект, бүдүүвч зураг, дадлагын хичээлийн төлөвлөгөө, шалгалтын тестийн асуултуудыг боловсруулсан. Дамжааны онолын болон дадлагын хичээлийг Афганистаны АЦХ-ний засвар, техникийн үйлчилгээний хорооны сургалтын материаллаг баазыг түшиглэн, хичээлийн танхим, техник ашиглалтын байр, нислэгийн зурвас дахь дадлагын нисдэг тэргэн дээр зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Нисдэг тэргэний техникийн засвар, үйлчилгээний сургалтын нэгдүгээр бүлэг нь "Ми-17" загварын нисдэг тэргэний хөдөлгүүрийн мэргэжлээр шилжүүлэн сургах дунд шатны дамжааг хоёр удаа амжилттай зохион байгуулсан. Бид сургалтыг зохион байгуулсан хугацаандаа Афганистан болон АНУ-ын АЦХ-ний удирдлага, бие бүрэлдэхүүн хэрхэн, ямар үнэлгээ өгөх бол, дараагийн үүрэг гүйцэтгэх бүлгийг хүлээн авах болов уу хэмээн санаа зовж байсан боловч дараагийн бүлгийг хүлээн авах шийдвэр гарч улмаар нийт найман дүгээр үүрэг амжилттай биелүүлсэн түүхтэй.

АФГАНИСТАН УЛСАД

10 ЖИЛ

СУРГАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ

Нэгдүгээр бүлгийн боловсруулсан сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөө нь дараа, дараагийн сургалтын бүлгүүдийн үндсэн баримт бичиг болсон юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчний АДХЦ-ийн "Нисдэг тэрэгний техникийн засвар, үйлчилгээний сургалтын бүлэг" нь найман удаа үүрэг гүйцэтгэж, Афганистан Улсын АЦХ-ийн нисэх хорооны инженер, техникийн бүрэлдэхүүнд "Ми-17 загварын нисдэг тэрэгний хөдөлгүүрийн мэргэжил"-ээр 250 цэргийн алба хаагчийг давтан сургалтад хамруулан мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлсэн.

Афганистан улсад Нисдэг тэрэгний техникийн засвар, үйлчилгээний сургалтын бүлгүүд үүрэг гүйцэтгэснээр Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн анги, салбарын офицер, ахлагч нарын мэргэжлийн хичээлийн онолын болон дадлагын ур чадвар нь дээшилсэн. Үүнийг Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн офицер, ахлагч нарын амжилтаас харж болно.

2017 оны Зэвсэгт хүчний "Тэргүүний заах арга зүйч офицер,

ахлагч" шалгаруулах тэмцээнд тус ангийн бодит шалгалтын бүлгийн дарга, ахмад Э.Отгонбаяр, нисэхийн техникийн засварын газрын их бие, хөдөлгүүрийн хэвшүүлэх ажлын бүлгийн ахлах механикч, ахлах ахлагч Э.Ариунболд нар оролцож, гуравдугаар байрыг тус тус эзэлсэн ба багийн дүнгээр тэргүүн байрт шалгарсан. Мөн ахмад Э.Отгонбаяр Зэвсэгт хүчний оны тэргүүний офицероор тодорч 2018 оны Зэвсэгт хүчний "Тэргүүний заах арга зүйч офицер, ахлагч шалгаруулах тэмцээн"-д ахлах дэслэгч Д.Алтансүх гуравдугаар байр, ахлах ахлагч Д.Гэндмаа тэргүүн байрыг тус тус эзлэн, багийн дүнгээр тэргүүн байрт шалгарсан юм. Мөн ахлах дэслэгч Г.Алтансүх Зэвсэгт хүчний Тэргүүний офицероор, 2019 онд Зэвсэгт хүчний Тэргүүний ахлагчаар ахлах ахлагч Д.Гэндмаа нар тус тус шалгарсан.

Аливаа ажиллагаа нь офицер, ахлагч нарын өөрийгөө хөгжүүлэх, дайчлан ажиллах чадварыг нэмэгдүүлдгээс гадна сэтгэл зүйн хувьд өндөр ачааллыг даах хатуужлыг суулгадаг өндөр ач холбогдолтой юм.

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ



Хошууч Д.Ганхуяг, Б.Бат-Эрдэнэ, дэслэгч С.Дэлгэрмягмар, А.Насанжаргал, сургагч ахлагч С.Гэрэлт-Од, энгийн Д.Түвшинтөгс

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ТАВДУГААР БҮЛЭГ



Дэд хурандаа З.Ганхуяг, ахлах дэслэгч С.Энх-Амгалан, дэслэгч Б.Дорждэрэм, Т.Ганчулуун, сургагч ахлагч С.Энхтайван, Ш.Цогбаяр

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ЗУРГААДУГААР БҮЛЭГ



Дэд хурандаа С.Цогтгэрэл, ахлах дэслэгч Б.Баясгалан, Г.Золзаяа, дэслэгч Р.Батжаргал, Д.Эрхэмбаяр, С.Сэргэлэнбат

СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦТАЙ ТАНИЛЦСАН ХҮНДЭТ ЗОЧИД

Дээрх бүлгүүдийг үүрэг гүйцэтгэх явцад ажиллагааны газар оронд гадаад улсуудын болон манай орны олон тооны хүндэт зочид очиж үүрэг гүйцэтгэлтэй нь танилцсан юм.

Тухайлан онцолбол, Анхны сургалтын бүлгийг үүрэг гүйцэтгэж байх үед Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайд Жонатан С.Аддлетон, Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Жонатан Д.Лау нар сургалтын бүлгийн үүрэг гүйцэтгэж буй нисэх хороонд ажлын айлчлал хийсэн юм. Хүндэт зочдыг дагалдан Үндэсний ахлах төлөөлөгч, хурандаа П.Батжаргал, Цэргийн багийн ажиллагааны офицер, хошууч Ч.Батхүү болон Аляскийн Үндэсний гвардын холбогч багийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн. АНУ-ын АЦХ-ийн 438 дугаар хорооны захирагч, хурандаа Кеннет Э.Мадура, 440 дүгээр эскадрилийн захирагч, хошууч Жосеф Стангл болон сургалтын бүлгийн бүрэлдэхүүн хүндэт зочдыг угтан авсан. Элчин сайд Жонатан С.Аддлетон болон бусад дагалдан яваа бүрэлдэхүүнд бүлгийн дарга, дэд хурандаа Ч.Болдбаатар сургалтын бүлгийнхээ үйл ажиллагааны талаар товч танилцуула хийсэн бөгөөд үүний дараагаар хурандаа Кеннет Э.Мадура, хошууч Жосеф Стангл нар Афганистаны АЦХ-ийн бие бүрэлдэхүүнтэй явуулж буй нисэхийн сургалтын ажиллагаа, Монгол Улсын Зэвсэгт хүчний Цэргийн багийн НТТЗУСБ-ийн зохион байгуулж байгаа дамжааны сургалтын онцлогийн талаар товч мэдээлэл хийсэн юм. Уулзалтын төгсгөлд Элчин сайд Жонатан С.Аддлетон

сургалтын бүлгийн бүрэлдэхүүнд НАТО-ийн дурсгалын медалийг гардуулж байлаа.

ХБНГУ-ын генерал Вольф Лангхелд тэргүүтэй зочид Каяа бааз дахь Афганистаны Агаарын цэргийн хүчинд дэмжлэг үзүүлэх зорилгоор Афганистан Улсад явагдаж буй Афганистан улс дахь командлалын үйл ажиллагаатай танилцах үедээ АНУ-ын Агаарын цэргийн хүчний дивизийн штаб, нислэгийн зурвас болон техник ашиглалтын байран дахь онгоц, нисдэг тэрэгний ашиглалт, засвар үйлчилгээний анги, АНУ-ын нисэх эскадриль, Хорват, Йордан, Чех, Унгар улсын нисэхийн сургалтын багууд "Монгол Улсын Зэвсэгт хүчний нисдэг тэрэгний техникийн засвар, үйлчилгээний бүлгийн бие бүрэлдэхүүнтэй уулзалтыг зохион байгуулж харилцсан туршлага солилцсон. Энэ үеэр генерал Вольф Лангхелд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн Нисдэг тэрэгний техникийн засвар, үйлчилгээний сургалтын бие бүрэлдэхүүнтэй уулзаж бүлгийн үүрэг, зорилго, боломж, зохион байгуулж буй сургалтын талаар асуулт тавьсан бөгөөд "Ми-17" загварын нисдэг тэрэгний хөдөлгүүрийн мэргэжлээр сургалтыг зохион байгуулж байгаа нь Афганистан Улсын Үндэсний армийг хөгжүүлэх зорилгоор явагдаж буй НАТО-ийн сургалтын ажиллагаанд оруулж буй та бүхний хувь нэмэр юм" гэж тэмдэглэн хэлээд цаашид дамжааныхаа сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулахыг сургалтын бүлгийн бие бүрэлдэхүүнд захиж байлаа.

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ДОЛООДУГААР БҮЛЭГ



Зүүн гар талаас: Ахлах дэслэгч Ц.Алтанцац, С.Дэлгэрмягмар, ахмад Ж.Цогтдорж, ахлах дэслэгч А.Насанжаргал, ахлагч Б.Ганболд, сургагч ахлагч Д.Оюунболд

НИСДЭГ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН НАЙМДУГААР БҮЛЭГ



Зүүн гар талаас: Дэслэгч Э.Отгонбаяр, Б.Энхболд, дэд хурандаа С.Цолмонбаатар, дэслэгч Э.Энхбаяр, Д.Батбилэг, арын эгнээнд дэслэгч Ч.Санждорж

АХМАДУУД ЗАДАММА ҮҮЦЭЭ

Монгол цэргийн нэгдсэн холбооноос санаачлан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас бэлтгэл болон чөлөөнд гарсан ахмадуудын уран бүтээл, цуглуулгын үзэсгэлэнг өнгөрсөн долоо хоногт Монгол цэргийн музейд дэлгэлээ.

Ахмадуудын шинжлэх ухаан, танин мэдэхүй, утга зохиол, урлаг, оюуны болон бусад уран бүтээл, цуглуулгыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, харилцан туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү үзэсгэлэн ихээхэн үүрэгтэй байсан төдийгүй тэдний ур ухаан, авьяас, чадвар харих болоогүй



гэдгийг нь улам тодоор илтгэн харуулж чадсан юм.

Үзэсгэлэнгийн нээлтэд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын дэд сайд М.Батбаяр, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, чөлөөнд байгаа дэслэгч генерал Ш.Арвай болон Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин, Хил хамгаалах Ерөнхий газар, Онцгой байдлын Ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын удирдлагууд, ахмад уран бүтээлчид оролцлоо.

Үзэсгэлэнг нээж Ерөнхий сайдын зөвлөх, Монгол цэргийн нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо үг хэлсэн ба Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын дэд сайд М.Батбаяр нар мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Мөн Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор, чөлөөнд байгаа дэслэгч генерал Ш.Арвай, Шинжлэх ухааны доктор, профессор, чөлөөнд байгаа хурандаа Х.Шагдар, Зохиолчдын эвлэлийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, цагдаагийн хурандаа Р.Гаваасүрэн, Үйлчилгээний гавьяат ажилтан, доктор, хурандаа П.Дамдин нарын бүтээлийг танилцуулж, гавьяат жүжигчин, бэлтгэл хурандаа Н.Чулуунхүү, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын дуучин Монгол Улсын гавьяат жүжигчин Б.Ганчимэг, цагдаагийн хошууч Ж.Алтангэрэл болон Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчид оролцож, ая дууны болон шүлэг, яруу найргийн дээжээ өргөн барив.

Ахмадууд анх удаа цуглаж бүтээл, цуглуулгаа олонд толилуулж байгаа бөгөөд өөрсдийн бичсэн шүлэг найргаа уншиж сонорыг нь мялаасан юм.

Тэд хамгийн эрхэм, үнэ цэнтэй гэсэн бүхнээ тус үзэсгэлэнд дэлгэн тавьсан байлаа. Тухайлбал, Цагдаагийн Ерөнхий газрын Ахмадын хорооны дэлгэсэн үзэсгэлэнд дэд хурандаа цолтой Руслан хэмээх эрэлч нохойн үзмэр олны сонирхлыг ихээхэн татаж байлаа. Эрэлч албаны нохой Руслан нь ОХУ-ын Нохойн албаны төв сургуульд дасгалжуулагч Г.Нэргүйн хамт суралцаж байхдаа Чех, Орос, Куба, Вьетнам, Болгар зэрэг орны сонсогчдын сургаж байсан 120 гаруй албаны нохойны дунд зохион

байгуулсан ерөнхий болон мэргэжлийн тэмцээнд тогтмол тэргүүн байрт шалгарч байснаас гадна Волгоград, Нальчик, Сочи, Ростов зэрэг хотод нохой сонирхогчдын уралдаан тэмцээнд таван удаа оролцож, тэргүүн байруудад удаа дараа шалгарч, мэргэжлийн дасгалаараа гурван удаа алтан медаль хүртжээ.

Мөн Руслан 10 гаруй жил манай улсын эрүүгийн албанд ажиллахдаа тухайн үеийн Худалдаа бэлтгэлийн газрын манаачийг трубагаар цохиж, 29 мянган төгрөгийг нь дээрэмдэн, амийг нь бүрэлгэсэн гэмт хэрэг, Дархан хотын нэгэн байгууллагын агуулахаас их хэмжээний хүнсний бараа хулгайлсан хэргийг илрүүлсэн, 30 гаруй удаагийн үйлдлээр олон тооны эд зүйл хулгайлсан этгээдүүдийг баривчлахад онцгой үүрэг гүйцэтгэсэн зэрэг 130 гаруй онц ноцтой хэргийг илрүүлсэн аж. Тэр ч байтугай тухайн үеийн онц ноцтой гэмт хэрэг үйлдээд зугтаасан оргодлын хутганд өртөж хоёр удаа шархдаж, оёо тавиулж байсан ч хэрэг илрүүлэх үүрэгт ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэж байсан тухай түүхийн хуудаснаа бичигдэн үлджээ. Русланы гавьяаг нь алдаршуулж хөшөөг нь босгосон байна.

Мөн Хил хамгаалах Ерөнхий газрын ахмадын хорооны дэлгэсэн үзэсгэлэнд бэлтгэл хурандаа В.Дамдинсүрэнгийн Монгол Улсын хилийг явганаар тойрсон үеийн дардас, тамга, тэмдэглэгээ бүхий газрын зургийг дэлгэн харуулжээ. 2016 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр эхэлсэн тус явган аялал нь Монгол Улсын 14 аймгийн 72 сумын нутгаар дамжин хилийн зурвасын дагуу өдөрт 20-25 км явж нийт 8252 км замыг туулан 12 дугаар сард дуусжээ. Тус явган аяллын багийнхан Монгол Улсын дархан хил, хилийн баганууд болон хилийн отряджуудаар дайрах бүрдээ тухайн газруудад жижүүрлэж байсан хилчин дайчдын дурсгалын зургийг буулгаж тэмдэглэгээг хийсэн нь эдүгээ түүх болон үлдсэн байх юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Ахмадын хороо бэлтгэл хурандаа Д.Цээсэнгийн судалгааны ном, гарын авлага зэргийг дэлгэн тавьжээ. Бэлтгэл хурандаа Д.Цээсэн гуайн хувьд энэ байгууллагад 30 гаруй жил ажиллаж чөлөөнд гарсныхаа дараа өөрийн бүтээлүүдээ бичиж эхэлсэн аж. Тэр багаасаа сэтгүүлч болохыг мөрөөддөг байсан бөгөөд урын сандаа түүхэн тэмдэглэл, дурсамж, яруу найраг, нийтлэлийн зэрэг 10 гаруй номтой ажээ.

Мөн тус үзэсгэлэнд бие даан оролцож байгаа



Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ахмадуудын бүтээл аргагүй нүд хужирлаж байсан юм. Энд ахмадуудын гаргасан гарын авлага, номуудаас гадна монгол ахуй, ёс заншил, ур ухаан зэргийг шингээсэн бүтээлүүдийг дэлгэн тавьжээ. Тухайлбал, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан монгол гэр тавилгатайгаа байхаас гадна төр, засгаас гаргасан шийдвэрийг дэмжих зорилгоор урласан яндан хөөлөгч, үнсний хутгуур зэрэг авсаархан агаад хэрэглэхэд дөхөм багаж хэрэгсэл ч дэлгэгдсэн байлаа.

Мөн Батлан хамгаалах яамны Ахмадын хорооны дэлгэн тавьсан бүтээлүүдийг дурдалгүй өнгөрч болохгүй юм. Тус хэсэгт БХЯ-наас тэтгэвэр, чөлөөндөө гарсан ахмадуудын болон одоо ч Зэвсэгт хүчиндээ өөрийн мэдлэг, чадвараа харамгүй зориулж байгаа олон тооны ахмад уран бүтээлчдийн оюуны бүтээлүүдийг дэлгэсэн нь олны анхаарлыг татсан юм.

Эх орныхоо төлөө залуу нас, хөдөлмөр, зүтгэлээ зориулсан тэд маань хүсэл сонирхол, авьяас билгээрээ нэгдэн, дурсамж, дурдатгалаа хуваалцан мөн л ихийг амжуулсаар яваа нь энэхүү үзэсгэлэнгээс харагдаж байв. Ийнхүү нийт 14 байгууллагын ахмадууд анх удаагаа уг үзэсгэлэнг хамтран гаргасан бөгөөд ирэх жил илүү өргөн хүрээнд зохион байгуулах саналаа Монгол цэргийн нэгдсэн холбооны удирдлагад уламжилж байлаа.



БХЯ-ны шатрын аваргууд тодров

Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын нэрэмжит Шатрын аварга баг, тамирчин шалгаруулах тэмцээний эрэгтэй төрөлд ахлах дэслэгч А.Одпүрэв (ГХАГ), хурандаа Д.Содномцог (СБТГ), дэд хурандаа Г.Одбаяр (ГХАГ), эмэгтэйчүүдийн төрөлд хурандаа Ц.Ганчимэг (ГХАГ), Ж.Амаржаргал (ХШУДАГ), ахлах дэсдэгч Ц.Хишигсүрэн (СБТГ) нар эхний гурван байрыг эзлэв.

Багийн дүнгээр Гадаад хамтын ажиллагааны газрын баг тэргүүлж, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын хамт олон удааллаа.

Тус тэмцээний шүүгчээр олон улсын хэмжээний их мастер Б.Мөнгөнтуул, Ц.Батчулуун нар ажилласан юм.

Хурандаа Д.СОДНОМЦОГ

Оюуны спортоор өрсөлдөө

Зэвсэгт хүчний Жанжин штабын Ар талын газрын Зэвсэглэлийн хэлтсийн нэрэмжит Зэвсэгт хүчний 2020 оны шатрын аварга шалгаруулах тэмцээн явагдлаа. Энэ удаагийн тэмцээнийг Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Цэргийн зэвсэглэлийн хэлтсийн дарга агсан, хурандаа О.Сэрдариин мэндэлсний 100 жилийн ойн нэрэмжит болгон зохион байгуулсан юм.

Тэмцээнд Зэвсэгт хүчний 10 ангийн 30 гаруй баг оролцсоноос багийн дүнгээр ҮБХИС, ЗХЖШ-ын Ахмадын хороо, Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн багууд эхний байруудыг эзэллээ. Харин ганцаарчилсан төрөлд дэслэгч Б.Алтансүх (338), сонсогч Б.Сэржбүдээ (ҮБХИС), бэлтгэл дэд хурандаа Ч.Ренчинбазар нар бусдыгаа манлайлав.

Дэд хурандаа Д.НЯМГЭРЭЛ

Анхан шатны сургалтад хамрагдав

Зэвсэгт хүчний 256 дугаар анги Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургууль, Цэргийн хөгжмийн коллеж, Ахлагчийн сургуулийг төгсөж тус ангид томилогдсон шинэ бүрэлдэхүүнд "Ажлын байрны анхан шатны сургалт"-ыг явуулж, 2020 оны II ээлжийн цэрэг татлагаар хугацаат цэргийн албанд ирсэн дайчдад ангийн үйл ажиллагааг танилцуулав.

Сургалтын төгсгөлд сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, ангийн уран сайханчдын хэсэгчилсэн тоглолтыг үзүүллээ.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН

Авьяас чадвараа "гайхуулаа"

Зэвсэгт хүчний 325 дугаар анги Завхан аймгийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн төвтэй хамтран "Тэргүүний ардын авьяастан шалгаруулах урлагийн үзлэг"-ийг зохион байгууллаа.

Урлагийн үзлэгийг холимог найрал дуу, найрал дууны чуулга, гоцлол дуу, ардын язгуур урлаг, уран уншлага, шилдэг гоц үзүүлбэр зэрэг төрлөөр явуулж, ангийн алба, салбар, нэгжүүд бүрэн хамрагдав. Тэргүүний ардын авьяастан шалгаруулах урлагийн үзлэгт командын байр, штаб, ар талын багууд бусдыгаа хошуучиллаа.

Номын санч Д.ЭНХЗАЯА

Геодези, зураг зүй-90

Зэвсэгт хүчний 284 дүгээр анги Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, "Кад Сөрвэй" ХХК хамтран зохион байгуулсан "Шилжин явах цом"-ын төлөө "Геодези, зураг зүй-90" спортын цогцолбор тэмцээнд төрөл тус бүрд эрэгтэй, эмэгтэй баг тамирчдыг бэлтгэн амжилттай оролцууллаа. Тус тэмцээн нь Монгол Улсад геодези, зураг зүйн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан явагдсанаар онцлог бөгөөд гар бөмбөгийн эрэгтэй төрөлд ахмад З.Ариун-Эрдэнэ ахлагчтай баг, сагсан бөмбөгийн эмэгтэй төрөлд ахмад Б.Хишигсүрэн ахлагчтай баг, ширээний теннисний төрөлд Т.Бат-Энх тэргүүн байрыг эзэллээ. Мөн сагсан бөмбөгийн холын зайн шидэлтийн тэмцээнд энгийн Б.Минжин түрүүлж өргөмжлөл, мөнгөн шагнал хүртлээ. Тэмцээний нэгдсэн дүнгээр тус анги гуравдугаар байрыг эзэлсэн юм.

У.БАЯНДАЛАЙ



ЦЭРГИЙН НЭГДСЭН ДЭЭД СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИЙН 30 ЖИЛИЙН ОЙД

ЦЭРГИЙН АНДУУДЫН НӨХӨРЛӨЛ ЦААШИД Ч ҮРГЭЛЖИЛНЭ ЭЭ ...

Найз нөхдийн нандин дурсамж дотроос цэргийн андуудын гэгээн дурсамж өнө мөнхийн байж, тэдний насан туршийн нөхөрлөл нь амьдралын туршид үргэлжилдэг гэдэгт байнга итгэж, бишрэн хүндэлж явдаг хүний нэг нь би билээ. Аливаа хүмүүн насан туршдаа нандигнасан олон сайхан дурсамж хэдэн арваар тоологдох найз нөхөдтэй байдаг нь хэн бүхэнд ойлгомжтой. Гэхдээ цэргийн хуаранд ижилдэн дасаж, дуутай жагсаалд алхаа нийлүүлж, өглөөний бослогоос оройн зугаалга, тооллого хүртэлх бүхий л хугацааг хамтдаа өнгөрүүлж, нэгээс дөрвөн жилийн хугацаанд

ажилласан юм. Бидний төгссөн оны хувьд "Цагаан морин жил" байсан ба эх орон даяар ардчиллын салхи хүчтэй салхилж, их, дээд сургууль төгсөгчдийн хувьд философи, түүх, нийгмийн ухааны улсын шалгалтыг өгөхөөс татгалзаж, олон ургалч үзэл, шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийг бодитойгоор өрнүүлэн улс орон маань төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж байсан үе юм. Ийм л онцлог цаг үед бид офицерын албанд томилогдсон бөгөөд тухайн цаг үеэ дагаад олон нөхөд маань хувийн бизнес эрхлэн нэлээд олонх нь ганзагын наймаанд хүчээ сорьж,

дүүрэн байсан нь илт мэдрэгдсэн юм. Хүндэт зочдын дотор ротын захирагч асан бэлтгэл хурандаа Н.Эрдэнэ, курсийн дарга асан бэлтгэл хурандаа Ч.Хуягтбаатар, чөлөөнд байгаа ахмад Д.Пүрэвдаш, С.Галбадрах, Д.Мандах, "Карантин"-ы жагсаалын дарга асан бэлтгэл дэд хурандаа Л.Гантөмөр нар манлайлах үүрэгтэй оролцож билээ.

Харин энэ өдөр 120 гаруй төгсөгчид цугларсан бөгөөд тэдний манлайд Ерөнхий сайдын зөвлөх Л.Алтангэрэл, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, БХЯ-ны Бодлогын

Артиллерийн курсийн сонсогч асан Д.Отгонбаяр хэлсэн үгэндээ "Хэдхэн



хормын өмнө сүлд хийморь, зориг баатарлагийн оройн дээд шүтээн болсон Байлдааны тугандаа 30 жилийн дараа хүндэтгэл үзүүлсэндээ сэтгэл догдлон буй "онжав"-ууддаа энэхүү баярын өдрийн мэндийг дэвшүүлэе. Бидний хувьд хэзээ ч мартагдашгүй, давтагдашгүй, нэн дурсамжтай энэ л уулзалт, баярыг зохион байгуулж байгаа эрхэм

хандивласан бөгөөд энэхүү хүндтэй үүргийг Ерөнхий сайдын зөвлөх Л.Алтангэрэл хүлээж, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Сургалт, цэргийн алба эрхэлсэн тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очирт гардуулсан юм.

Баярын хурал, хүндэтгэлийн цуглааны ажиллагаа өндөрлөсний дараа Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчдийн нэгдсэн тоглолтыг төгсөгчдөд үзүүлсэн ба тоглолтын хөтөлбөрт бидний сонсогч насанд дуулагдаж байсан олон дуу багтсан учраас тэд дээрх дуунуудыг уран бүтээлчдийн хамтаар цугтаа дуулж, нэгэн өдрийг баясал дүүрэн өнгөрүүлээ. Тоглолтын үеэр нэгэн оны төгсөгчдөд зориулан бэлтгэл хурандаа Д.Байгалийн бичсэн шүлгээр гавьяат жүжигчин Н.Чулуунхүү хөгжмийг нь зохиосон "Цэргийн нөхөрлөл" хэмээх шинэхэн дуу төрсөн нь тэдний сэтгэлийн нандин утсыг хөндөж билээ.

Энд ганц жишээг тодруулахад, монгол түмний болоод цэргийн алба хаасан хэн бүхний



нэг л цэргийн байранд амьдарч, өдөр тутмын хичээл сургууль, хээрийн гаралт, полигоны дадлагад цугтаа хичээллэж, соёлын төв, биеийн тамирын зааланд чөлөөт цагаа хамтдаа өнгөрүүлэхийн хамт нэгдсэн журмаар нэг дор хооллож, чухамдаа тугийн доор зэрэгцэж, тушаал дор амьдарч, цэргийн дүрэм, заавраар жигд амьсгалж явна гэдэг аливаа бүхэнд тохиох хувь заяа биш гэлтэй.

Тиймээс цэргийн нөхөрлөл нь насан туршийн дурсамжтай гэсэн тодотголтой явдгийн бодит жишээ энэ билээ. Эрхэм уншигч таны хувьд ч энэ тухай тодруулбал, эр цэргийн тангараг өргөж, энэ л хүндтэй албыг хаасан хэн бүхний амнаас хангалттай сонссон гэдэгт эргэлзэх юун билээ.

Энэ тухай төрийн шагналт зохиолч Ч.Чимэд "Дайчин нөхрийн тухай" дуундаа

**Саарал шинелиэ тайлаагүй
Буурал найз минь хаана байна
Дархан хотын барилга дээр үү
Торгон хилийн зааг дээр үү
Дууны ая хангинасан
Найрын дуунд танилцаагүй
Бууны дуу тачигнасан
Дайны галд танилцсан юм
Нэгэн эхээс цуван төрж
Нэхий өлгий дамжаагүй юм
Цэргийн хуаранд ихэр болж
Цэгц журмын нөхөр болсон юм**

хэмээн уран яруу өгүүлсэн нь нүдэнд харагдаж, нэгийг бодогдуулах ажээ.

Энэ бүхнийг нуршин өгүүлэхийн учир нь эдүгээгээс 34 жилийн тэртээ тухайн үеийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн ариун жагсаалд нэгдсэн дайчин нөхдийнхөө нөхөрлөлийн үнэ цэнийг ойлгуулахыг зорьсон нь тэр билээ.

Бид тэртээ 1986 оны 8 дугаар сарын 1-ний өдөр эх орныхоо өнцөг бүрээс энэ л сургуулийнхаа хашаанд цугласан түүхтэй бөгөөд чухамдаа

**"Будилж явсан багынхаа
занг орхиж
Буугаа үүрсэн сонсогч болсон
Түмэн олноо амгалан
байлгах гэж
Төр, улсдаа тангараг өргөсөн
насан туршийн андууд"**
болсон түүхтэй.

Тэр л оны намар бидний 200 гаруй сонсогчид цэргийн тангаргаа өргөснөөс хойших дөрвөн жилийн хугацаанд хамтдаа амжилт дүүрэн суралцсан бөгөөд тэртээх он жилүүд алсран одсон ч одоо мэт санагдах нь нэн бахдалтай.

Энэ мэт бүхий л дурсамжийг дэлгэсэн цэргийн андууд маань энэ сарын 7-ны өдөр алдар гавьяаны хос одонтой, амжилт бүтээлийн 99 жилийн бахархам түүхтэй, их жанжны нэрэмжит төрөлх сургуулийнхаа жагсаалын талбайд цуглан төгсөлтийнхөө 30 жилийн ойн баярыг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлж билээ. Цэргийн андууд маань 1990 оны зун Цэргийн нэгдсэн дээд сургуулийг өөрсдийн сонгосон мэргэжлээр дүүргэж дэслэгчийн алтан мөрдсөө гялалзуулан эх орныхоо өнцөг бүхэнд байрлах Ардын Армийн анги, салбаруудад томилогдож

эх орныхоо хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулсан жамтай.

Тэдгээр дурсамжийг хүүрнэн, цэргийн нөхөрлөлөө баталгах, үеийн нөхдийнхөө ажил, амьдралтай гүнзгий танилцах, сургуулийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлэхийг эрхэм болгосон төгсөлтийн ойн баяраа нэгдсэн журмаар хийх талаар олон санал, санаачилга өрнөсний эцэст энэ л өдрийг сонгож, хамтдаа чуулсан нь тэр билээ. Тэрчлэн бид энэхүү уулзалтынхаа үндсэн зорилгыг Цэргийн нэгдсэн дээд сургууль төгсөгчдийн 30 жилийн ойн баярыг зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэн өнгөрүүлэх, төгсөгчид, тэдний гэр бүл, үр хүүхдүүдэд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин, Үндэсний батлан хамгаалахын их сургуулиар бахархах сэтгэлийг төрүүлж, төрөлх сургуулийнхаа үйл ажиллагааг сурталчлах, иргэн-цэргийн харилцаа, цэргийн дайчин нөхөрлөлийг бэхжүүлэх хэмээн тодорхойлсон юм.

Цэргийн нэгдсэн дээд сургуулийг төгсөгчдийн дотроос бригадын генерал хэмээх эрхэм дээд цолтон нэг, хурандаа цолтон 20 гаруй төрсөн бөгөөд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад ажиллаж буй ахлах офицерууд, гавьяаныхаа амралтаа эдэлж яваа бэлтгэл офицерууд ч цөөн бус байлаа. Нөгөө талаар хувийн хэвшлийн салбарт амжилт дүүрэн яваа найзуудынхаа амжилтаас цухас мэдэрсэн бөгөөд энгэрт нь гялалзах "Алтан гадас" одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, салбар бүрийн тэргүүний ажилтны цол, тэмдэг нь тэдний амжилт бүхнийг нь илэрхийлж буй нь үнэхээр бахадмаар байсан. Энэхүү төгсөлтийн ёслолын ажиллагаанд 1990 онд төгсөгчдөөс гадна тухайн үед биднийг удирдаж байсан рот, курсийн дарга нар болон сургалтын төвийн жагсаалын дарга, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцлоо.

Эл баяраа тэмдэглэхээр ирсэн хүндэт зочид, төгсөгчдийг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Сургалт, цэргийн алба эрхэлсэн тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очир, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн захирал, хурандаа М.Болдбаатар тэргүүтэй удирдах албан тушаалтнууд утган авсан ба төгсөгчдөд ёслолын ажиллагааны хөтөлбөрийг танилцуулснаар үндсэн үйл ажиллагаа эхэлсэн юм.

Ёслолын ажиллагааны эхэнд төгсөгчдийг курсийн зохион байгуулалтад оруулан сургуулийн төв индрийн дэргэд жагсааны дараа Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Сургалт, цэргийн алба эрхэлсэн тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очир тус сургуулийн Байлдааны тугийг залсан юм. Цэргийн хөгжмийн яруу тунгалаг аялгуу дор тус сургуулийн Байлдааны тугийг Хүндэтгэлийн байранд залсны дараа төгсөгчид курсийн зохион байгуулалтаар сургуулийнхаа Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэхдээ өөрийн эрхгүй ихэд баярлаж, зарим нь баярын нулимс дуслуулан бахдал

хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Х.Батсайхан, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, хурандаа О.Нямчулуун, ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, Удирдлага, холбоо, мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дарга, хурандаа М.Золзаяа, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа З.Майдар, Архангай, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Ганбаатар, Н.Нацагдорж Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Дашдорж, Зэвсэгт хүчний 232, 310 дугаар ангийн захирагч, хурандаа Н.Мягмарцож, Ж.Баясгалан, Нийслэлийн Онцгой байдлын газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Ч.Гансүх нар жагссан юм.

Ийнхүү Байлдааны тугандаа хүндэтгэл үзүүлсний дараа төгсөгчид Жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөсөн бөгөөд хүндэт зочдын хамтаар дурсгалын зураг авахуулахад тун идэвхтэй хамрагдлаа. Энэ үеэр сургуулийн жагсаалын талбайд "Тэмүүжин Өрлөг" сургуулийн сурагчдын жагсаалын үзүүлэх тоглолтыг үзүүлсэн ба тэднийг үзүүлбэрээ дуусган жагсаалын алхаагаар алхахад нь сонсогч үеэ дурсан төгсөгчдийн зүгээс гүн хүндэтгэлтэйгээр баяр хүргэн улам их амжилтыг хүсэж билээ.

Мөн энэхүү баярын хөтөлбөрт тусгаснаар Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн штаб, Батлан хамгаалахын удирдлагын академийн хичээлийн танхимуудаар орж, сургуулийн үндсэн үйл ажиллагаатай танилцсаны зэрэгцээ тус сургуулийн музейг курсийн зохион байгуулалтаар шимтэн үзсэн нь бас л нэгийг бодогдуулсан биз ээ.

Үүний дараа "Тэмүүжин Өрлөг" сургуулийн хурлын зааланд төгсөгчдийн баярын хурал, хүндэтгэлийн цуглааныг зохион байгуулсан ба энэхүү ёслолын ажиллагааг нээж Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатарыг үг хэлсний дараа Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэх ахуйд төгсөгчид нийтээр даган дуулсан нь үнэхээр бахдам байлаа.

Энэ үеэр бэлтгэл хурандаа Д.Байгаль, хурандаа Ц.Анхбаяр, бэлтгэл хурандаа Б.Болдбаатар, төгсөгч Д.Отгонбаяр, хурандаа М.Золзаяа, Ч.Баатарзориг, бэлтгэл дэд хурандаа О.Мөнхням, хурандаа Ж.Баясгалан нар Ерөнхий цэргийн "А", "Б", Улс төр, Артиллери, Холбоо, Авто, Танк, Ар талын курсийнхээ төгсөгчдийг тайзнаа урин тэдний дэлгэрэнгүй танилцуулгыг хийж, найз нөхдийнхөө амжилтын буухиаг илтгэж байсан нь бахархах сэтгэлийг төрүүлсэн. Дээрх танилцуулгыг хийсэн журмын нөхдийн дотроос



нөхөдөө чин сэтгэлийн талархал илэрхийлэе. Ажил, амьдралын арвин замыг туулж, алдаж оносоор ирсэн өнгөрсөн он жилүүдэд цагийн аясыг дагаж, аливаа сорилт, бэрхшээлийг амжилт дүүрэн даван гарах сэтгэлийн хат, тэсвэр хатуужил, эх оронч хүмүүжлийг бүрнээ төлөвшүүлсэн, хөрвөх чадвартай мэргэжлийг эзэмшүүлсэн төрөлх сургууль, эрдэмтэн багш

бахархал болсон "Манай цэргийн жавхаа" дууг тус чуулгынхан дуулахад төгсөгчид суудлаасаа болсон нэн хүндэтгэлтэйгээр даган дуулсан бичлэгийг цахимд байршуулснаар даруй 3000 гаруй үзэгчийн хүртээл болоод байгаа нь бас л нэгийг бодогдуулж буй гэдэгт эргэлзэх юун билээ.

Төгсөгчид дээрх ёслолын ажиллагааны дараагаар



нар, рот, курсийн захирагчдаа цаг ямагт баярлаж, тэднээрээ бахархаж явдаг илэрхийлэхийг хүсэж байна" гэдгийг онцолсон юм.

Тэрхүү танилцуулгын дараа Батлан хамгаалахын сайдын тушаалаар зарим рот, курсийн захирагч нар болон "Карантин"-ы жагсаалын даргыг Батлан хамгаалах яамны шагналаар шагнасныг нь Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Х.Батсайхан, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, хурандаа О.Нямчулуун нар гардуулсан юм. Мөн төгсөгчдийн энгээнээс тодорсон ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, доктор, бригадын генерал Ч.Цогтжаргал номын дээжийг хийморийн морины хамтаар дурсган хүндэтгэл үзүүлсэн бөгөөд эрхэм генерал маань нийт төгсөгчид, эрдэмтэн багш нартаа талархсан сэтгэлээ бахархал дүүрэн илэрхийлж билээ.

Энэхүү уулзалт, төгсөлтийн ёслолын ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийнхэн төрөлх сургуулийнхаа сургалт, соён гэгээрүүлэх болон мэдээлэл, сурталчлагааны ажилд нэн шаардлагатай байсан асуудлыг нь шийдвэрлэхийг эрхэм болгон Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Соёлын төвийн хэрэгцээнд 12 зам бүхий чадлын эсрэгчид хос яригчийн хамтаар

сургуулийнхаа гал тогоонд сонсогч үеийн үдийн хоолоо зооглосон ба тогооч, бэлтгэгч нарын зүгээс бидний байнгын идэх дуртай байсан шөлтэй хоол, гулшийг бэлтгэсэн байсны зэрэгцээ тухайн үеийг минь санагдуулахаар талхыг зургаа хуваан нэг дор тавьсан нь ч содон байв. Түүний зэрэгцээ одоогоос 34 жилийн тэртээ биднийг анхны амгат хоолоор дайлан тогооч Ж.Шүрэнцэцэг эгч маань энэхүү үдийн хоолны үеэр ирж бүх төгсөгчдийг эхийн халуун сэтгэлээр тэврэн мэндчилсэн нь бас л нэгэн бахархал байлаа.

Тэрхүү үдийн зоогийн дараагаар төгсөгчид Цэргийн нэгдсэн дээд сургууль, Аюулгүй байдлын дээд сургуулийн үйл ажиллагаатай товч танилцан өөрийн төрөлх цэргийн тэнхимүүдээрээ зочилсноор энэхүү баяр маань ёслол төгөлдөр өндөрлөсөн юм.

Энэ л төгсөлтийн баяр, дурсамж дүүрэн уулзалтыг амжилттай зохион байгуулсан ажлын хэсгийнхэнд хандсан чин сэтгэлийн талархлын үгс өнөөдөр ч ирсээр байгаа нь дараа дараагийн төгсөгчдөд бодит үлгэрлэл болж, тэр бүхнээс санаа авах буй заа хэмээх зорилгын үүднээс ийнхүү дэлгэрэнгүй толилуулсан нь энэ билээ.

Цэргийн андуудын дайчин нөхөрлөл цаашид ч өнө мөнхөд үргэлжлэх болно.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ШИНЭХЭН БАЙЛДАГЧ

(Түрүүч нь I нүүрт)

Б.Азжаргал нь айлын бага хүү бөгөөд нэг эгчтэй. Өөрийнх нь хэлснээр нэлээд дураараа өссөн хүүхэд аж. Дураараа өссөн ч эцэг, эхийнхээ чихийг "халууцуулсан" тохиолдол тун цөөхөн хэмээн хэлсэн юм. Гэхдээ эргэтэй хүүхэд л болсон хойно аав, ээжийнхээ нүүрийг ганц, хоёрор тогтохгүй "улзалуулах" зүйлийг хийжээ. Тухайлбал, 7 настай байхдаа тэрээр анх удаагаа цэргийн ангид хөл тавьсан бөгөөд энэ өдрөө "тэнгэрт тулсан" том хэрэг тарьжээ. Тэднийх 16 дугаар хороололд амьдардаг байсан бөгөөд нэг найзынхаа хамтаар БХИС-ийн хашааг давж орон тоглогсон байна. Түүгээр ч зогсохгүй хугацаат цэргийн байраар нь орж ханан дээр нь өлгөөстэй байх хүндэт самбар дахь зургуудыг нь харж яваад ротын жижүүр,



иржээ. Б.Азжаргалын хувьд өмнө дурдсан их сургуульд уул, уурхайн чиглэлээр сурдаг тул мэргэжилтэй нь ойр, өөрт нь дадлага болно гэсэн үүднээс тус ангид алба хаах хүсэлтэй байгаагаа илэрхийлэн хуваарилагджээ. Тус ангид ирсэн даруйд ая тухтай, тохилог орчин, зөлдөг харилцаатай захирагч, дарга нар угтсанаар дээр өгүүлсэн анхны сэтгэгдэл нь тэс өөрөөр эргэсэн ажээ. Сурч мэдэхийн төлөө хичээж зүтгэвэл юун загнуулах, харин ч магтаал, урмын үгс харамгүй сонсдог гэдгийг мэдэрчээ. Түүний хувьд захны даавуугаа гуравхан удаа ханзлуулсан гэж онгирох маягтай хэлсэн. Гэхдээ төгс оёж сураагүй байгаа талаар хэлэхийн зэрэгцээ иргэний нийгэмд өөрийгөө

Б.Азжаргал: ЭР ХҮНИЙ ХААХ ЁСТЛОЙ АЛБА ТЭЖ "ТАШУУРДСАН"

Ээлжтэнд баригдан сургуулийн жижүүрт байцаалт өгсөн аж. Сургуулийн жижүүр тэр хоёроос "Хэнтэй хамт яваа юм, хэний хүүхдүүд вэ" гэхчлэн асуултууд тавихад айсандаа самбар дээрх зураг руу нь зааж "Тэр хүний дүү" хэмээн хэлсэн нь асуудлыг улам ч хурцатгаж "өндөр" авахад хүргэсэн талаар дурссан. Хэрвээ тэр үед хажуу байрны хүүхдүүд гэсэн бол сургуулийн жижүүр нэг сайн загнаж өгөөд л гаргах байсан биз. Тэр тусмаа нийгэм солигдож, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл агуулга бус хэлбэр талаасаа "шүтэгдэх"

сонирхол аав, ээжид нь байсан бөгөөд "Эр хүн болсных яваад ирэх алба" хэмээн "ташуур" өгсөн байна. Б.Азжаргалын хувьд хугацаат цэргийн албанд явахаар нэгэнт шийдсэн үедээ багынхаа хоёр найзыг хамтдаа явъя гэж нэлээд ятгасан боловч ятгалгад нь оролгүй үлджээ. 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр түүнийг цэрэг татлагын "комисс"-оор орох үед аав нь "Миний хүү олны дунд үгээ бодож яваарай" гэж захисан байна. "Комисс"-оор ороод явж байхад тэнд байсан нэг дарга "саналаараа явах хүсэлтэй хүн байна уу" гэж асуухад маш

дайчлаад сурахгүй байсан энгийн зүйлсийг цэрэг амьдралын нэг жилийн хугацаанд дарга нарынхаа хүчээр суралцана гэдэгтээ итгэлтэй байгаа аж. Тэр бээр "Ээж минь надад ажил хийвэл дуустал нь хий. Тэгэхдээ цаг хугацаанд нь бүрэн гүйцэд хийж бай" гэж олон удаа хэлсэн. Тухайн үед нь сайн ойлгохгүй, үл тоосон маягтай хүлээж авдаг байлаа. Цэргийн албанд ирээд аливаа ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэд хийх нь тухайн хүнд амьдралын маш сайн дадал, зуршил өгдөг гэдгийг мэдэрч байна. Өглөө эрт босож, ороо цэвэрхэн, зөв хураах



болсон өнөө үед залуус хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах болсон. Харин оюутан Б.Азжаргал тэгэлгүй цэргийн зарлан дуудах хуудас авсан мөчөөс "Одоо явах нь зөв үү, эсвэл их сургуулиа төгсөөд явах нь зөв үү" гэсэн асуултыг өөрөөсөө болон найз нөхөд, гэр бүлийнхнээсээ асууж, зөвлөлдсөн аж. Тэр үед дээрх бүх хүмүүс явсан нь дээр, гэхдээ чиний сонголт чухал, өөрөө шийд дээ гэж хэлжээ. Харин цэрэгт явах талаараа сургуулийнхаа багш нар болон оюутнуудад хэлээгүй байна. Учир нь хэрвээ цэрэгт явлаа гэж сүр дуулиан болоод, баяр ёслолын байдалтай үдүүлчихээд, "комисс"-оор ороод тэнцэхгүй бол хүмүүсийн хандлага, өөрийгөө үнэлэх үнэлэмжид нь нөлөөлөх байсан талаар дурссан. Ганц хүүгээ цэргийн албанд мордуулах

олон залуус өөртэй нь нэгэн адил гараа өргөхийг нь хараад "Өөрийн хүсэлтээр явна гэдэг нь тийм ч гайхуулаад байх зүйл биш" гэдгийг мэдсэн талаараа ярьсан юм. Үзлэгээр ороход төсөөлж байснаас нь хэр өөр байсан талаар асуухад "Хар хувцастай хүмүүс "комисс"-оор орж байгаа залуустай нэлээн ширүүн харьцаж байгаа нь маш эвгүй байсан. Цэргийн ангидаа очоогүй байхад ингэж байгаа юм чинь очих юм бол бүр ч "эвгүй" харьцаатай хүмүүс угтах байх даа" гэж бодсон ч бас нуугаагүй. Түүний хэлсэн "эвгүй" харилцаатай хар хувцастай хүмүүс гэдэг нь цэргийн дүйцүүлэх албыг хааж байсан иргэд аж. Улаанбаатар хотод анхны цас орж, шуурга тавьсан өдрийн үүрээр алба хаах ангидаа буюу Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн байрлалд

гээд жижиг мэт боловч хүнийг бусдад зөвөөр харагдуулах амьдралын хэвшилд суралцаж байгаа. Мөн дураараа өссөн хүний хувьд багаар ажиллах, хамтдаа хийх зэрэг дараа нь түүнд хэрэгтэй олон зүйлсийг өдөр бүр өөрийнх болгож гэж хичээж байгаагаа Б.Азжаргал ярьсан юм. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх "Цэргийн алба бол эр хүнийг, өрхийн тэргүүнийг бэлтгэдэг сайхан алба" гэж нэгэнтээ хэлсэн. Тэгвэл 2020 оны хоёрдугаар ээлжээр Б.Азжаргал болон түүнтэй хамт нэг ээлжинд татагдан ирсэн залуус эр хүн болохоор цэргийн эрдэмд шамдан суралцаж, тулгатай өрхийн тэргүүн болж төлөвшихөөр бэлтгэгдэж байна. **Ахмад Э.ОЧХҮҮ**

Үндэсний бахархал, ӨВ СОЁЛ



САЙН УДИРДЛАГЫН ҮЕ

Дэслэгч Сэрээтэр нь байлдагчдыг сурган хүмүүжүүлэхийн тулд цэргийн дүрмийн шаардлагыг зөвөөр баримталж буй хүмүүсийг чадамгайгаар удирддаг. Сургуулийг заахаас 2-3 хоногийн өмнө өөрийн биеийг сайнаар бэлтгэж конспект төлөвлөгөөг хийж дээд даргаараа батлуулдаг. Сургуулийг заахдаа үзүүлэн таниулах хэрэглэлийг сайн бэлтгэх буюу жинхэнэ бие баримттай зүйлүүд дээр энэ сургуулийг явуулдаг байна. Энэ учраас дэслэгч Сэрээтэрийн салбар анги энэ улс төр, байлдааны бэлтгэл сургуулийн талаар ахмад Нанзадын анги дээр тэргүүлж байна. Энэ бол нөхөр Сэрээтэрээс байлдагчдын дотор үргэлжлэн ажиллаж тэдний эрэлт хүсэлтийг хангаж цаг ямагт бие биеэ үлгэрлэн сургаж байсны үр нь юм. Дарга хүний өндөр сурлага, сахилга журмын хатуу бэхжил хэчнээн өндөр байх тусам байлдагчдын сурлага хүмүүжилд их ашигтай нөлөөг үзүүлж чаддаг. Энэ туршлагаа улам батжуул.

Батлан хамгаалахын Төв архивын сан хөмрөгөөс "Улаан одон" сонин 1943.01.10 Дугаар №8 /1271/ хуудас-3

Мэргэжлийн зөвлөгөө

ӨВЛИЙН ДУГУЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ

Бүх улирлын дугуй хэмээн зарагддаг дугуй нь өвлийн улиралд яг тохирсон байж чаддаггүй. Шавар болон цасны (M+S) тэмдэглэгээ нь бүх улирлын дугуйн дээр байдаг ч яг өвлийн улиралд зориулсан дугуйны хэмжээнд хүрдэггүй. Өвөлд зориулсан дугуй нь хажуудаа цас борооны логотой, бусад дугуйнаас хол илүү чанартай байдаг. Бүх дугуй нь хөтлөгч системтэй автомашинд өвлийн дугуй хэрэгтэй, эсэх тал дээр эргэлзэж байж магадгүй. Дугуй нь өргөн мөртэй бол гулгалтыг багасгадаг. Гэхдээ дуу гарах нь бусад дугуйнаас илүү байдаг. Харин хажуудаа мөртэй бол замтай илүү барьцалдах чадвартай гэсэн үг. Бүх дугуйн хөтлөгч систем нь гулгамтгай нөхцөлд тэнцвэртэй байдлыг хангахад магадгүй туслах байх. Гэхдээ зогсоохыг хүссэн үед тусалж чадахгүй гэдгийг нь санах хэрэгтэй. Өвлийн дугуй нь бүх улирлын дугуйнаас богино зайд зогсож байсан бөгөөд үүнийг 50 км/цагийн хурдтайгаар туршиж үзсэн аж. Өвлийн дугуй нь бүх улирлын дугуйнаас 25 хувь илүү богино зайд зогсож байсан бөгөөд энэ нь хоёр эсвэл гурван машины урттай дүйцэхүйц хэмжээс юм. Бүх улирлын дугуй нь -7 хэмээс эхлэн ашиг тустай байдалаа алдаж эхэлдэг. Тиймээс дээрх бүх зөвлөгөөг мөрдөж дугуйгаа өвлийн дугуйгаар солих нь Таныг болзошгүй зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлнэ гэдгийг анхааруулж байна.



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны байцаагч, дэслэгч Б.БАТХУЯГ

"МАСКАА ЗҮҮЦГЭЭ, ГАРАА УГААЯ" АЯН ЭХЭЛЛЭЭ

ТА БУСДАДАА ЗӨВ ШААРДЛАГА ТАВЬСНААР БҮГД АЮУЛТ ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЖ ЧАДНА

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч **Хурандаа Батжаргалын ОТГОНБАЯР**
Эхийг "Соёмбо" сонины редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029